



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 673

Улаанбаатар хот

**“Говь-Алтай АЗЗА” төрийн өмчит хувьцаат
компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөг батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Говь-Алтай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2022 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ш.Тогтмол)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-г даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132007125

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
633 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ГОВЬ-АЛТАЙ АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он		2022 оны Төлөвлөгөө	Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Хүлээгдэж буй гүйцэтгэл		2022 Төл/ 2021 Төл	2022 Төл- 2021 Төл
1	Нийт орлого	мян.төг	1,008,417.60	1,024,664.80	704,303.10	952,015.80	92.9	(72,649.00)
	Үүнээс: Улсын чанартай зам засварын ажил	мян.төг	583,243.10	664,664.80	567,015.80	767,015.80	115.4	102,351.00
	Бусад	мян.төг	425,174.50	360,000.00	137,287.30	185,000.00	51.4	(175,000.00)
2	Нийт зардал	мян.төг	995,125.10	1,005,783.80	740,277.80	947,255.70	94.2	(58,528.10)
3	Удирдлагын зардалд	мян.төг	168,860.30	203,115.40	178,938.90	201,846.80	99.4	(1,268.60)
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	13,292.50	18,881.00	(35,974.70)	4,760.10	25.2	(14,120.90)
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	11,910.40	16,992.90	(35,974.70)	4,284.10	25.2	(12,708.80)
6	Төсвийн төлбөрт	мян.төг	177,418.60	167,414.00	133,014.70	164,304.20	98.1	(3,109.80)
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	мян.төг	600.00	1,340.90	0.00	642.60	47.9	(698.30)
8	Нийт өглөг	мян.төг	4,728.80	13,260.50	34,545.60	13,145.20	99.1	(115.30)
9	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	284,319.30	293,846.20	308,059.40	293,666.50	99.9	(179.70)
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	283,600.90	283,600.90	24,458.50	10,065.60	98.2	(179.70)
	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төгрөг	0.99	0.98	1.05	0.99	101.0	0.01
10	Хөрөнгө оруулалт	мян.төг	67,830.00	75,000.00	67,640.00	80,709.00	107.6	5,709.00
11	Ажиллагсдын тоо	хүн	30	32	32	35	109.4	3.00
12	Цалингийн сан	мян.төг	306,436.50	338,654.40	274,357.40	336,081.20	99.2	(2,573.20)
13	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	851.20	881.90	714.50	714.50	81.0	(167.40)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
67 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**“ГОВЬ-АЛТАЙ АЗЗА” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
1	Гаражийн барилгын дээврийн засварын ажил	ш	1	19,209.00	19,209.00
2	Суурин компьютер	ш	1	2,500.00	2,500.00
3	Зөөврийн компьютер	ш	1	3,500.00	3,500.00
4	Үйлчилгээний автомашин	ш	1	17,500.00	17,500.00
5	Трайлер чиргүүл	ш	1	38,000.00	38,000.00
	НИЙТ ДҮН				80,709.00